



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг

Утас/Факс: 976-70333141

И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2013.05.18 № 205
танай _____-ны № _____-т

**ГҮЙЦЭТГЭЛ НИЙЦЛИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.ЭНХБОЛД ТАНАА**

Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан нэгдсэн удирдамжийн дагуу “Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг хүргүүлж байна.

Хавсралт 19 хуудастай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.БАЙГАЛМАА





ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮР ДҮНД СУУРИЛСАН САНХҮҮЖИЛТИЙН
ТОГТОЛЦООНД ШИЛЖСЭНЭЭР ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ
САЙЖИРЧ БАЙГАА ХЭДИЙ Ч ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР
ОРХИГДОЖ БОЛЗОШГҮЙ БАЙНА

АУДИТЫН НЭР: ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ, ҮР ДҮНД СУУРИЛСАН
САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦОО, ҮР НӨЛӨӨ

АУДИТЫН КОД:
АРА-2023/19-01-ШТА-ГА



ЦЭЦЭРЛЭГ ХОТ
2023 ОН

Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141 Цахим хаяг: baigalmaat@audit.gov.mn
Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860 Цахим хаяг: nerguibaatard@audit.gov.mn
Багийн ахлагч, ахлах аудитор П.Цэцэгдулам
Утас: 9933-9725 Цахим хаяг: tsetsegdulamp@audit.gov.mn
Аудитор В.Цогжаргал
Утас: 9915-8257 Цахим хаяг: tsogjargalb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

Тайлан бэлтгэсэн: Архангай аймаг дахь Төрийн аудитын газар	➤ Товчилсон үгийн тайлбар ➤ Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй
Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Аудитын менежер Д.Нэргүйбаатар Ахлах аудитор П.Цэцэгдулам Аудитор В.Цогжаргал 2023 оны 05 дугаар сар Уг тайланг www.audit.mn сайтаас үзнэ үү. Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах зүйл байвал 7033-2860 дугаарын утас, 7033-3141 дугаарын факсаар харилцана уу Хаяг: Эрдэнэбулган сум Аймгийн ЗДТГ-ын байр 3-р давхар 314 тоот	БҮЛЭГ 1. ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮДЭД ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ УЯЛДАА ХОЛБОО, ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОН НУТГИЙН ТҮВШИНД ХАНГАН АЖИЛЛАЖ БАЙНА Зорилт А1. Хөгжлийн бодлогын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгийн хүрээнд орон нутгийн эрүүл мэндийн чиглэлээр тусгагдсан арга хэмжээ 75.5 хувийн хэрэгжилттэй үнэлэгдсэн байна БҮЛЭГ 2. ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГААС ИРГЭДЭД ҮЗҮҮЛЭХ ЗАРИМ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САНХҮҮЖИЛТ ЭМД-ЫН ГЭРЭЭГЭЭР ХЯЗГААРЛАГДАЖ БАЙНА Зорилт Б.1. Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгож байгаа боловч орлого бүрэн төвлөрөхгүй байна Зорилт Б.2. Эрүүл мэндийн даатгалын үр дүнд суурилсан тогтолцоонд шилжсэнээр эрүүл мэндийн салбарт тодорхой ахиц дэвшил гарах нөхцөл бүрдэж эхэлж байна Зорилт Б 3. Орон нутгийн эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь хяналтыг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж байна Дүгнэлт Зөвлөмж Тайлан баталгаажуулсан тушаал Холбогдох байгууллагын санал Хавсралт:Судалгаанууд Хүснэгтийн товьёг Хүснэгт №1 Аймгийн ЭМДС-гийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, даатгалд хамрагдалтын судалгаа Хүснэгт №2 ЭМДС-гаас олгосон санхүүжилтийн судалгаа Хүснэгт №3 ЭМДХ-гийн цахим болон эмч байцаагчийн хяналтын судалгаа Графикийн товьёг График №1. ЭМДС-гаас гэрээгээр үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд График №2. ЭМД-д хамрагдалт, насны бүлгээр График №3. Хүүхдийн дунд бүртгэгдсэн тэргүүлэх 5 өвчлөл График №4. Насанд хүрэгчдийн дунд бүртгэгдсэн тэргүүлэх 5 өвчлөл График №5 Санал асуулгын

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	<i>Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт</i>
МУЕА	<i>Монгол Улсын ерөнхий аудитор</i>
МУЗГ	<i>Монгол Улсын засгийн газар</i>
ЭМДЕГ	<i>Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар</i>
ЭМДС	<i>Эрүүл мэндийн даатгалын сан</i>
ЭМДХ	<i>Эрүүл мэндийн даатгалын хэлтэс</i>
ЭМЯ	<i>Эрүүл мэндийн яам</i>
НДЕГ	<i>Нийгмийн даатгалын ерөнхий газар</i>

АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ:

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2022 оны 9 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г тус тус үндэслэн, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлээ.

НИЙЦЛИЙН АУДИТЫН ЗОРИЛТ:

Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө сэдвээр гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт зөвлөмж гарган, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэнэ.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэлээ. Үүнд:

- ✓ Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн, төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдсан эсэх
- ✓ Эрүүл мэндийн байгууллагаас даатгуулагчийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эсэх

АУДИТЫН ХАМРАХ ХҮРЭЭ:

Аудитад аймгийн Эрүүл мэнд даатгалын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд, өрх, сумын эрүүл мэндийн төвүүд, хөнгөлөлттэй үнээр үйлчилдэг эмийн сангуудын 2021-2022 онд эрүүл мэндийн даатгалын сангаас авсан санхүүжилтийн гүйцэтгэлийг хамруулан шалгалаа.

АУДИТЫН АРГА ЗҮЙ:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 300, 3000-3200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-3:2020, 6817-5:2020, 6817-7:2020, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам болон Гүйцэтгэлийн аудитын заавар аргачлал, Нийцлийн аудитын холбогдох стандартад заасан арга зүйг ашиглан салбарын бодлого, тогтолцоо, үйл ажиллагаатай холбоотой баримт материалыг үндэслэн тулган баталгаажуулалтыг хийж, тухайн асуудал хариуцсан албан тушаалтнаас асуулга лавлагаа, тодруулга авах зэрэг горимыг хэрэгжүүлж, аудитын асуудлын шинжилгээ болон арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт зөвлөмж боловсрууллаа.

АУДИТ ХИЙХ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН:

Аудитыг Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа хянан удирдаж, аудитын менежер Д.Нэргүйбаатар үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлэн ажиллах бөгөөд ахлах аудитор П.Цэцэгдулам, аудитор Г.Цогжаргал нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлээ.

Асуудлын шинжилгээний А1.2, А1.3, Б3.1, Б3.3 дахь асуултууд орон нутагт хамааралгүй болно.

БҮЛЭГ 1. ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮДЭД ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ УЯЛДАА ХОЛБОО, ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОН НУТГИЙН ТҮВШИНД ХАНГАН АЖИЛЛАЖ БАЙНА

A.1.1 "Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилтын 2.2-д “Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлнэ” гэж тусгасан байна. Зорилтын хүрээнд 1-р үе шат буюу 2021-2030 онд “Эрүүл мэндийн чанар, хүртээмжтэй тогтолцооны шинэчлэлийн үе”-ийг хэрэгжүүлэх буюу “Нотолгоонд суурилсан орчин үеийн оношилгоо, эмчилгээний техник, технологийн дэвшлийг нэвтрүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, гүйцэтгэлд тулгуурласан санхүүжилт, даатгалын тогтолцоотой болсон байна” гэжээ.

Энэ хүрээнд Эрүүл мэндийн байгууллагууд нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжсэнээр, лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээг зөвхөн гүйцэтгэлд суурилсан, анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэгч сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийг нэг иргэнээр тооцсон болон гүйцэтгэлд суурилсан төлбөрийн аргаар санхүүжүүлэх тогтолцоо хэрэгжиж эхэлсэн байна.

Аймгийн засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн хөгжлийн 2021, 2022 онуудын төлөвлөгөөнд эрүүл мэндийн чиглэлээр цахим монгол арга хэмжээний хүрээнд:

- ✓ Эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх
- ✓ Орон нутагт хийгдэх оношилгоо эмчилгээнд алсын зайн технологи ашиглах
- ✓ Цахим эрт илрүүлэг, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн оновчтой арга хэлбэрийг нэвтрүүлэх үйл ажиллагааг дэмжих, эрүүл мэндийн даатгалын тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх
- ✓ Эм эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдлыг хангах
- ✓ Хяналтын цахим тогтолцоонд шилжихтэй холбоотой зорилт арга хэмжээг тусган ажилласан байна.

Бодлогын хүрээнд Аймгийн засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн хөгжлийн 2021, 2022 оны төлөвлөгөөнд эрүүл мэндийн чиглэлээр тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсээс хэрэгжилтийг 75.5 хувьтай үнэлэгджээ.

Эндээс үзэхэд төрөөс баримтлах бодлогын баримт бичгүүдэд эрүүл мэндийн чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний уялдаа холбоо, хэрэгжилтийг орон нутгийн түвшинд ханган ажиллаж байна.

БҮЛЭГ 2. ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГААС ИРГЭДЭД ҮЗҮҮЛЭХ ЗАРИМ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САНХҮҮЖИЛТ ЭМД-ЫН ГЭРЭЭГЭЭР ХЯЗГААРЛАГДАЖ БАЙНА

Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгож байгаа боловч орлого бүрэн төвлөрөхгүй байна

Б1.1 Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.1-19.1.9-д заасан эх үүсвэрүүдээс бүрдэхээр заасан. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлагын төлөвлөгөө орон нутагт хийдэггүй бөгөөд Нийгмийн даатгалын ерөнхий газар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар хооронд байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу аймаг, нийслэлийн эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын хуваарь, шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг даатгуулагчийн хамралтын төлөвлөгөөг Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн тогтоолоор баталж Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлдэг байна. Үүний дагуу аймгийн нийгмийн даатгалын хэлтэс нь сангийн орлогыг төвлөрүүлдэг байна.

2021 онд эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлого **3,837.5** сая төгрөг төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр **3,789.8** сая төгрөгийн орлого төвлөрүүлж төлөвлөгөө 98.7 хувийн хэрэгжилттэй, 2022 онд **9,401.4** сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр **4,529.9** сая төгрөгийн орлого төвлөрч төлөвлөгөө 48.2 хувийн хэрэгжилттэй байна.

Аймгийн 2021, 2022 оны Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэл, хамрагдалтыг даатгуулагчийн төрлөөр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 1. Аймгийн ЭМДС-гийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, даатгалд хамрагдалтын судалгаа /сая.төгрөг/

Үзүүлэлт	2021 оны хамрагдалт, шимтгэлийн орлого					2022 оны хамрагдалт, шимтгэлийн орлого				
	Төлөвлөгөө		Гүйцэтгэл			Төлөвлөгөө		Гүйцэтгэл		
	тоо	дүн	тоо	дүн	хувь	тоо	дүн	тоо	дүн	хувь
Ажил олгогч, даатгуулагчийн төлөх шимтгэл	-	3,228.5	14757	3,241.1	100.0	-	8,460.1	15537	3,703.0	100.0
Дүн	-	3,228.5	14757	3,241.1	100.0	-	8,460.1	15537	3,703.0	100.0
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	3750	182.7	3208	164.6	85.5	3375	282.4	3515	248.0	104.1
Малчин	15800	365.4	4798	329.1	30.4	12400	564.8	5650	496.0	45.6
Оюутан, суралцагч	2500	60.9	565	54.9	22.6	2000	94.1	479	82.7	23.9
Дүн	22050	609.0	8571	548.6		17775	941.3	9644	826.7	
ЭМД-ын шимтгэл төлөх хугацааг хэтрүүлсэнд ногдуулсан алданги				0.2					0.2	
НИЙТ ДҮН	22050	3,837.5	23328	3,789.9		17775	9,401.4	25181	4,529.9	

Хүснэгтээс харахад 2022 онд ажил олгогч даатгуулагчийн төлөх шимтгэлийн орлогын төлөвлөгөөг өмнөх оноос 2.6 дахин өндөр төлөвлөсөнтэй холбоотой орлого

бүрэн төвлөрөөгүй, харин Эрүүл мэндийн даатгалд малчин, оюутан суралцагчийн нийт хамрагдалт хангалтгүй буюу 2021-2022 онд 26.5-34.7 хувьтай байна.

Б.1.2 Эрүүл мэндийн байгууллагуудад даатгалын сангаас олгох санхүүжилтийг ЭМДЕГ-аас олгодог тул орон нутагт бодит гүйцэтгэлийг үнэлэх боломжгүй байна

Эрүүл мэндийн даатгалын сангаас эрүүл мэндийн байгууллагуудад 2021 онд **17,528.7** сая төгрөг, 2022 онд **32,848.4** сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2 Эрүүл мэндийн байгууллагуудад олгосон санхүүжилтийн судалгаа

Он	Нэхэмжилсэн		Хасагдал		Олгохоор тооцсон дүн		Олгосон дүн /сая.төг/	Өглөгийн дүн /сая.төг/	Авлагын дүн /сая.төг/
	Хүний тоо	Дүн /сая.төг/	Хүний тоо	Дүн /сая.төг/	Хүний тоо	Дүн /сая.төг/			
2021	367653	24,592.1	4851	2,916.9	362802	21,675.2	17,528.7	4,146.5	
2022	431109	30,588.1	6055	1,925.9	425054	28,662.2	32,848.4		39.7

Хүснэгтээс харахад 2021 онд нийт 367,653 хүний 24,592.1 сая төгрөгийн нэхэмжлэл ирүүлсэнд цахим болон эмч байцаагчийн хяналтыг хийж **4851** хүний **2,916.9** сая төгрөгийн нэхэмжлэлд хасалт хийж 362,802 хүний **21,675.2** сая төгрөгийн гүйцэтгэлээр санхүүжилтийг олгохоор тооцсоноос ковид-19 цар тахалтай холбоотой нөхцөл байдлын улмаас **17,528.7** сая төгрөгийн санхүүжилтийг олгож **4,146.5** сая төгрөгийн санхүүжилт дутуу олгогдсон буюу өглөг үүссэн байна.

Харин 2022 онд нийт 431,109 хүний 30,588.1 сая төгрөгийн нэхэмжлэх ирсэнд цахим болон эмч байцаагчийн хяналтаар **6055** хүний **1,925.9** сая төгрөгийн нэхэмжлэлд хасалт хийж 425,054 хүний **28,662.2** сая төгрөгийн гүйцэтгэлээр санхүүжилтийг олгохоор тооцсоноос өмнөх оны өглөгийг бүрэн барагдуулж **32,848.4** сая төгрөгийг олгосноос 2 ЭМБ-тай холбоотой 39.7 сая төгрөгийн авлага үүсэж тайлагнагдсан байна.

Б1.3. Аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь хүн хүчний нөөц хязгаарлагдмал байдлаас шалтгаалан хяналтын зарим чиг үүрэг бүрэн хэрэгжихгүй байна

Монгол Улсын засгийн газрын 2017 оны 344 дүгээр “Агентлаг байгуулах тухай” тогтоолоор Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрыг байгуулснаар орон нутгийн эрүүл мэндийн даатгалын хэлтсүүд байгуулагдсан байна.

Архангай аймаг дахь Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь дарга-1, чанарын төлбөрийн хяналтын мэргэжилтэн-2 гэсэн бүтэцтэй ажиллаж байна. Тус хэлтэс нь нэхэмжлэлийн нарийвчилсан хяналтыг хийх, нэхэмжлэлийн хяналтын үр дүн, эрүүл мэндийн байгууллагуудад хяналт, шалгалт, чанарын үнэлгээ хийх, чанар, төлбөрийн хяналтад дүн шинжилгээ хийж тайлагнах, эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлагын гүйцэтгэлийг хангах чиг үүрэгтэй бөгөөд төсөв санхүүтэй холбоотой зарцуулалт орон нутгийн даатгалын хэлтэст хийгддэггүй байна.

2021 онд нийт 75 байгууллагын 367,653 хүний нэхэмжлэлд, 2022 онд нийт 71 байгууллагын 431,109 хүний нэхэмжлэлд системийн болон эмч байцаагчийн хяналтыг, 32 эрүүл мэндийн байгууллагад газар дээрх хяналт шалгалтыг хийсэн байна.

Аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтэст жилд дунджаар 399,381 хүний нэхэмжлэл ирдэг бөгөөд үүнийг 3 орон тоонд харьцуулахад нэг хүн жилд дунджаар 133,127 хүний, сард 11,093 хүний нэхэмжлэлд цахим болон эмч байцаагчийн хяналтыг хэрэгжүүлдэг байна.

Эрүүл мэндийн даатгалын хэлтсээс аймгийн эрүүл мэндийн байгууллагуудад нэхэмжлэлийн нарийвчилсан хяналтыг цахим болон эмч байцаагчийн хяналтаар хэрэгжүүлж байгаа хэдий ч эрүүл мэндийн байгууллагуудад хяналт, шалгалт, чанарын үнэлгээ хийх, чанар, төлбөрийн хяналтад дүн шинжилгээ хийж тайлагнах, эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлагын гүйцэтгэлийг хангах чиг үүргийн хэрэгжилтийг бүрэн хэрэгжүүлээгүй байна. Тухайлбал:

Аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь цахим болон эмч байцаагчийн хяналтаас гадна бодит буюу нөхцөл байдал дээрх хяналтыг 2021 онд аймгийн төвийн 7-н эрүүл мэндийн байгууллагад, 2022 онд аймгийн төвийн 19-н эрүүл мэндийн байгууллага, 2 сумын 6-н эрүүл мэндийн байгууллага нийт 25-н эрүүл мэндийн байгууллагад хийжээ.

Эндээс үзэхэд 2021-2022 онд эрүүл мэндийн байгууллагуудад хяналт, шалгалт, чанарын үнэлгээ хийх чиг үүргийг аймгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаа 75 байгууллагын 9.3-33.3 хувийг хамарсан боловч чанар, төлбөрийн хяналтад дүн шинжилгээ хийж тайлагнах чиг үүргийг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь бүтэц зохион байгуулалт болох хүн хүч, машин техникийн хязгаарлагдмал нөөцтэй холбоотой гэж үзэхээр байна.

Аудитаас эрүүл мэндийн даатгалын хэлтсийн хяналт, шалгалт, чанарын үнэлгээнд хамрагдах эрүүл мэндийн байгууллагын тоог нэмэгдүүлэх, чанар, төлбөрийн хяналтад дүн шинжилгээ хийж тайлагнах чиг үүргийн хэрэгжилтийг бүрэн ханган ажиллах зөвлөмжийг Эрүүл мэндийн даатгалын хэлтэст хүргүүллээ.


Аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн 2021, 2022 оны жилийн эцсийн нэгтгэсэн тайлан мэдээ алдаатай, зарим тоон мэдээллийг орхигдуулан, зөрүүтэй тайлагнасан байна. Цаашид "Бүртгэл тайлангийн маягтыг шинэчлэн батлах тухай" Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/355 дугаар тушаалын хавсралт маягтаар гаргаж байгаа бүртгэл, тайлан мэдээг алдаагүй үнэн зөв тайлагнаж ажиллах зөвлөмжийг хүргүүллээ.

Б.1.4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын сонгон шалгаруулах үйл ажиллагааг 3 жилд нэг удаа ЭМДЕГ-т зохион байгуулж байгаа нь орон нутагт зайлшгүй шаардлага үүссэн нөхцөлд тусламж үйлчилгээг үзүүлснээр ЭМД-ын санхүүжилтийг авч чадахгүйд хүрч байна.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 02 дугаар тогтоолоор баталсан "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг

сонгон шалгаруулах журам"-ын 3.1-т "Сонгон шалгаруулалтын бэлтгэл хангах, зохион байгуулах, хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах, гэрээ байгуулах эрх олгох шийдвэрийн санал боловсруулах үндсэн нэгж нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын сонгон шалгаруулалт, гэрээлэлтийн асуудал хариуцсан нэгж байна" гэж заасан. Үүний дагуу Эрүүл мэндийн даатгалын байгууллагаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын сонгон шалгаруулах үйл ажиллагааг орон нутагт зохион байгуулдаггүй бөгөөд Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын сонгон шалгаруулалт гэрээлэлтийн асуудал хариуцсан нэгж зохион байгуулсан байна.

Аймгийн хэмжээнд 2021 онд 48 эмийн сан, 29 эрүүл мэндийн байгууллага давхардсан тоогоор 21 тусламж үйлчилгээг худалдан авахаар, 2022 онд 41 эмийн сан, 30 эрүүл мэндийн байгууллага давхардсан тоогоор 24 тусламж үйлчилгээг худалдан авахаар сонгон шалгаруулалтад оролцож, гэрээг байгуулсан байна. График 1.



“Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журам”-д “Сонгон шалгаруулалтыг **гурван жилд нэг удаа** нэгдсэн журмаар зохион байгуулна” гэж заасан хэдий ч энэ хугацаанд даатгалын байгууллагатай гэрээлээгүй оношийн бүлгээр зайлшгүй нөхцөл байдлын улмаас нэн яаралтай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг иргэдэд үзүүлэх хэрэгцээ шаардлага үүсдэг байна. Үүний улмаас тус эрүүл мэндийн байгууллага нь иргэдэд үзүүлсэн тусламж үйлчилгээний санхүүжилтийг даатгалын байгууллагаас нэхэмжлэх боломжгүй байдалд хүргэх хүндрэл бэрхшээл тулгарч байна.

Аудитаас “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журам”-д “Сонгон шалгаруулалтыг **гурван жилд нэг удаа** нэгдсэн журмаар зохион байгуулна” гэсэн заалтыг эргэн харж шаардлага хангасан тохиолдолд жил бүр эрүүл мэндийн байгууллагууд оролцох боломжийг бий болгох нөхцөлөөр хангах, нэмэлт шалгаруулалтад хязгаарлалт тогтоохгүй байх саналыг ЭМДҮЗ-д уламжилж байна.

Б1.5. 2021-2022 онд орон нутгийн эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь эрүүл мэндийн байгууллагуудын гэрээний хэрэгжилтийг 85-95 оноогоор үнэлсэн байна

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-т “Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь энэ хуулийн 16.1.4-т заасны дагуу сонгон шалгаруулалтад тэнцсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага болон эмийн сантай даатгалын гэрээ /цаашид “гэрээ” гэх/-г байгуулах бөгөөд гэрээний хэрэгжилтийг хянаж, дүгнэнэ” гэж заасан. Үүний дагуу эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд 2021, 2022 онд Эрүүл мэндийн

даатгалын ерөнхий газартай тусламж үйлчилгээ худалдан авах гэрээг байгуулсан байна.

Аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь 2021 оны жилийн эцсийн Өрх, сумын эрүүл мэндийн төв болон эмийн сангийн гэрээний биелэлтийг ЭМДЕГ-ын даргын 2018 оны А/142 дугаар тушаалаар батлагдсан "Даатгалын гэрээ дүгнэх журам"-ын 2 дугаар хавсралт "даатгалын гэрээ дүгнэх үнэлгээний хуудас"-ын 15 шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байна. Үнэлгээгээр 2021 онд гэрээ байгуулсан 21 өрх, сумын эрүүл мэндийн төвөөс 17 байгууллага 85 оноотой, 4 байгууллага 90 оноотой дүгнэгдэж дундаж үнэлгээ 86 хувьтай дүгнэгдсэн байна. Эмийн сангийн тухайд 48 эмийн сан гэрээ байгуулснаас 43 эмийн сан жилийн эцсийн гэрээ дүгнэх үнэлгээнд материалаа ирүүлсэн байна. Үүнээс 2 эмийн санг 60-69 оноогоор, 2 эмийн санг 70-80 оноогоор, 39 эмийн санг 81-100 оноогоор тус тус үнэлсэн байна. Харин хөнгөлөлттэй эмийн үйлчилгээ үзүүлээгүй 2, гэрээ дүгнүүлэх материал ирүүлээгүй 2, хөнгөлөлттэй эмийн үйлчилгээг 1-8 сар үзүүлээд үйл ажиллагаа явуулаагүй 1 нийт 5 эмийн сангийн гэрээ дүгнээгүй байна.

2022 онд хөнгөлөлттэй эмээр үйлчлэх гэрээ байгуулсан 41 эмийн сангаас 3 эмийн сан явцын хяналтаар гэрээний шаардлага хангаагүй тул хугацаанаас өмнө гэрээ цуцалж, 38 эмийн сан гэрээ дүгнүүлэх материалаа аймгийн эрүүл мэнд даатгалын хэлтэст ирүүлж хэлтсийн чанар төлбөрийн хяналтын мэргэжилтнүүд ЭМДЕГ-ын удирдамжийн дагуу гэрээг дүгнэсэн байна. Нийт дүгнэгдсэн эмийн сангаас 11 эмийн сан 70-80 оноогоор, 27 эмийн 85-95 оноогоор үнэлэгдсэн байна. Үүнээс 70-75 оноотой 2 эмийн санд зөрчил арилгуулах улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага, 9 эмийн санд зөвлөмжийг хүргүүлж, хэрэгжилтийг хангуулсан байна.

Бусад эрүүл мэндийн байгууллагуудын 2022 оны даатгалын гэрээний хэрэгжилтийг ЭМДЕГ дүгнэсэн бөгөөд гэрээ дүгнэсэн талаарх мэдээлэл одоогоор ирээгүй байна. /Аймгийн ЭМДХ-ийн даргын 2023.05.16-ны өдрийн 12/33 тоот албан бичиг/

Б1.6. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад олгосон санхүүжилтийн үр нөлөө эхлэл төдий байна

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн нийт 75 байгууллагад 2021 онд 11 тусламж үйлчилгээний хүрээнд 17,528.7 сая төгрөг, 2022 онд 71 эрүүл мэндийн байгууллагад 12 тусламж үйлчилгээний хүрээнд нийт 32,848.4 сая төгрөгийн олгожээ.

Эрүүл мэндийн байгууллагууд гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжсэнээр мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг буцаан төвлөрүүлэхгүй дараа оныхоо үйл ажиллагаанд зарцуулдаг болсон байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 3. Лавлагаа шатлалын болон анхан шатны эрүүл мэндийн байгууллагад 2022 онд ЭМДС-гаас олгосон санхүүжилтийн судалгаа

/сая төгрөг/

ЭМБ-гуудын нэр	Олгосон санхүүжилт	Гүйцэтгэл	Үлдэгдэл
-------------------	-----------------------	-----------	----------

Нэгдсэн эмнэлэг	13,780.6	12,361.2	1,419.4
Сум, өрхийн ЭМТ	15,416.7	14,315.6	1,101.1
Нийт дүн	29,197.4	26,676.9	2,520.4

Эрүүл мэндийн байгууллагууд нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжиж, лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээг зөвхөн гүйцэтгэлд суурилсан, анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэгч сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийг нэг иргэнээр тооцсон болон гүйцэтгэлд суурилсан төлбөрийн аргаар Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх болсноор тусламж үйлчилгээнд дараах өөрчлөлт, үр нөлөө бий болж эхэлж байна.

Тухайлбал:

- ✓ Нэгдсэн эмнэлэг нь 2021 онд 10 тусламж үйлчилгээний хүрээнд 11,289.2 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байсан бол 2022 онд 4 тусламж үйлчилгээ нэмэгдэж нийт 14 тусламж үйлчилгээний хүрээнд 11,107.9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй ажилласан байна.
- ✓ Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд нь 2021 онд өдрийн эмчилгээ, сэргээн засах, гэрийн сувилахуй, оношилгоо шинжилгээ гэсэн 4 тусламж үйлчилгээний хүрээнд 6,154.8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байсан бол 2022 онд тусламж үйлчилгээний тоо **4-р нэмэгдэж** /хэвтэн, яаралтай, түргэн тусламж, шүд/ нийт 8 тусламж үйлчилгээний хүрээнд 13,953.5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.
- ✓ Эмийн сангуудад 2021 онд 1,489.7 сая төгрөгийн, 2022 онд 1,694.4 сая төгрөгийн санхүүжилт авч өмнөх оноос 204.7 сая төгрөгөөр өссөн нь хөнгөлөлттэй эмийн нэр төрөл нэмэгдсэн, Новартис эмийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд 15 ерөнхий нэршлийн 24 тун хэмжээ бүхий эмийг Эрүүл мэндийн даатгалын сангийн 100 хувийн хөнгөлөлттэй үнээр олгох болсонтой холбоотой байна.
- ✓ Хувийн 6 эмнэлэгт 2021 онд 2,092.4 сая төгрөгийн гүйцэтгэлтэй ажилласан бол 2022 онд санхүүжилтийн гүйцэтгэл 661.6 сая төгрөгөөр буурсан нь тогтолцооны хүрээнд хийгдсэн сонгон шалгаруулалтаар зарим тусламж үйлчилгээг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхгүй болсонтой холбоотой байна.

*Эндээс үзэхэд шинэ тогтолцоонд шилжсэнээр ЭМБ-уудын үзүүлэх тусламж үйлчилгээний тоо, хүртээмж нэмэгдэх, тусламж үйлчилгээний төвлөрөл саарах, даатгуулагчийг санхүүгийн эрсдэлээс хамгаалах, эмнэлгүүдийн хооронд шударга өрсөлдөөнийг бий болгож, эмнэлгийн гүйцэтгэлийг сайжруулах сайн талууд бий болж байгаа хэдий ч нөгөө талдаа хэт гүйцэтгэлийн тоонд анхаарснаар тусламж үйлчилгээний **чанарт** сэргээр нөлөөлж, шаардлагагүй тусламж үйлчилгээний тоо нэмэгдэж болзошгүй байна.*

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн байгууллагуудтай холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Сумдын эрүүл мэндийн төвүүдийн тухайд:

- ✓ Сумдын 2022 оны Ковид-19 өвчний хэвтэн эмчлэх тусламж үйлчилгээний анхан шатны баримтыг шалгахад өвчний түүхэд онош ахиулсан, цахим болон СТ-1 маягтад бичигдсэн зарим эмчилгээ зөрүүтэй, өвчний түүхэд, эмчийн өдөр тутмын үзлэг, оношийн үндэслэл, гарах үеийн дүгнэлт бичигдээгүй,

өвчний түүхийг бүрэн хөтлөөгүйтэй зэрэг 7 сумын эрүүл мэндийн төвтэй холбоотой нийт 19.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Энэ нь Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/611 дүгээр тушаалын 10 дугаар хавсралтын СТ-1 маягт, 2021 оны А/549 дүгээр тушаалын 3-д заасан эмнэл зүйн шинж тэмдэг, ангилал, 5.3-д халдварын хүндийн зэргийг харгалзан хэрэгжүүлэх эмчилгээний менежмент, Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ худалдан авах гэрээний 3.8.2.3 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх 7 сумдын ЭМТ-тэй холбоотой нийт 19.3 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Төрийн сан дахь Эрүүл мэндийн даатгалын сангийн дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

2. **Аймгийн Нэгдсэн эмнэлгийн тухайд:**

- ✓ 2021 онд мэс заслын тасгийн гэмтлийн яаралтай тусламжийн хагалгаанд шаардагдах хугарлын хадаас, ялтас, бэхэлгээг иргэнээр авхуулсан боловч тусламж үйлчилгээний санхүүжилтийг эрүүл мэндийн даатгалын сангаас давхар нэхэмжилсэнтэй холбоотой нийт 2.7 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5.эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд өөрөө шууд төлсөн төлбөрийн баримтыг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас гаргуулах, 13 дугаар зүйлийн 13.1.8. "даатгуулагчийг хэвтүүлэн эмчлэх үед өвчний түүхэнд бичигдсэн эм, эмнэлгийн хэрэгслийн зардлыг өөрөөр нь гаргуулсан тохиолдолд зах зээлийн жишиг үнээр тооцон даатгуулагчид буцаан олгох" Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг худалдан авах гэрээний 2.4.11 " Гэрээний 1,2 дугаар хавсралтаар баталсан " Иргэний хариуцан төлөх төлбөр" -өөс өөр нэмэлт төлбөр авахгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитаас дээрх төлбөрийг даатгуулагчид нөхөж буцаан олгох төлбөрийн акт тогтоолоо.

- ✓ 2021 онд мэс заслын тасгийн гэмтлийн яаралтай тусламжийн хагалгаанд орсон 23 иргэнээс 4 иргэний хагалгааны хэрэглэгдэхүүн болох хугарлын хадаас, ялтас, бэхэлгээг иргэнээр авхуулсан боловч буцаан олгоогүй зөрчил аудитын явцад илэрсэн. Иймд үлдсэн 19 иргэнээр гаргуулсан боловч нөхөж олгоогүй зөрчил байж болзошгүй гэж үзлээ. Энэ нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5.эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд өөрөө шууд төлсөн төлбөрийн баримтыг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас гаргуулах; 13 дугаар зүйлийн 13.1.8. "даатгуулагчийг хэвтүүлэн эмчлэх үед өвчний түүхэнд бичигдсэн эм, эмнэлгийн хэрэгслийн зардлыг өөрөөр нь гаргуулсан тохиолдолд зах зээлийн жишиг үнээр тооцон даатгуулагчид буцаан олгох", Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг худалдан авах гэрээний 2.4.11 " Гэрээний 1,2 дугаар хавсралтаар баталсан " Иргэний хариуцан төлөх төлбөр" -өөс өөр нэмэлт төлбөр авахгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх 19 иргэнтэй холбоотой зөрчилд нарийвчилсан хяналт шалгалт хийн зөрчлийг арилгах хугацаатай албан шаардлагыг хүргүүллээ.

Анхан болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудын эмийн үлдэгдэлд ковид-19 цар тахлын үед ЭМЯ-наас хандиваар ирсэн 2023 онд хугацаа дуусах нийт 570.4 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл байгаагаас 58.3 хувь буюу 332.3 сая төгрөгийн эм эмнэлгийн хэрэгсэл нь хугацаа нь дуусаж ашиглагдахааргүй болсон байдал ажиглагдлаа.

Эрүүл мэндийн даатгалын үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжсэнээр эрүүл мэндийн салбарт тодорхой ахиц дэвшил гарах нөхцөл бүрдэж эхэлж байна

Б2.1. Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/41 дүгээр тушаалаар баталсан "Гэрээр сувилахуйн тусламж үйлчилгээ үзүүлэх журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.1 "Анхан шатны тусламж үйлчилгээг хүн амд ойртуулах, архаг, хүнд, хэвтрийн өвчтэй урт хугацаанд асаргаа сувилгаа шаардлагатай иргэдэд гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулахад тушаалын зорилго оршино" гэж заажээ.

Аймгийн Эрүүл мэндийн газраас газрын даргын 2022 оны А/34 дүгээр тушаалаар гэрийн тусламж үйлчилгээ шаардлагатай байгаа иргэдэд эмчилгээ, асаргаа, сувилгааг чанартай, үр дүнтэй хүргэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор эрүүл мэндийн байгууллагын сувилахуйн алба, ахлах сувилагч нарт заавар, чиглэл өгч ажилласан байна.


Аймгийн хэмжээнд 2022 онд сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа 1201 иргэнд гэрээр сувилахуйн тусламж үзүүлэх тусламж үйлчилгээг үзүүлж эрүүл мэндийн даатгалын сангаас нийт 48.8 сая төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Харин Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд "Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг шинжилгээ, оношилгоог зохион байгуулах журам"-ыг Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/139 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар, Даатгуулагчийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах төлбөрийг нь санхүүжүүлэх журам"-ыг ЭМДҮЗ-ийн 2022 оны 06 дугаар тогтоолоор тус тус баталсан байна.

Үүний дагуу урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, оношилгоо, шинжилгээний ажлыг зохион байгуулах аймгийн Засаг даргын 2022 оны 03 тоот албан даалгаврыг сумдын Засаг дарга, аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хүргүүлсэн байна. Аймгийн хэмжээнд тус эрт илрүүлэг үзлэг, оношилгоо шинжилгээнд хамрагдах 6 насны ангиллын хүрээнд нийт 95199 иргэн хамрагдахаас 2022.05.01-2022.12.31-ний байдлаар 15737 иргэн буюу нийт хамрагдвал зохих иргэдийн **16.5** хувь нь эрт илрүүлэгд хамрагдаж 264.5 сая төгрөгийн санхүүжилтийг

ЭМД-ын сангаас санхүүжүүлсэн байна. Үүнээс хавдрын 8 тохиолдол илэрч дараагийн шатлалын эмнэлэгт шилжүүлсэн байна.

График№2



Графикаас үзэхэд 18-30, 31-45, 46-60, 61-ээс насны хамрагдалт 2.0-8.4 хувьтай буюу хангалтгүй харагдаж байна. Эрт илрүүлгийн хамрагдалт хангалтгүй байгаа нь малчин, ажилгүй иргэд эрүүл мэндийн даатгалаа бүрэн төлөөгүй, насанд хүрэгчдийн эрт илрүүлэг үзлэгийг зөвхөн аймгийн Нэгдсэн эмнэлэгт хийж байгаа бөгөөд тоног төхөөрөмж, боловсон хүчний хувьд дутмаг, эрт илрүүлэг үзлэгийн ач холбогдлын талаарх иргэдийн мэдлэг мэдээлэл төдийлөн сайн биш байна.

Б2.2. Эрүүл мэндийн байгууллагуудад ашиглагдаж байгаа цахим систем хоорондоо уялдаа холбоо муутай, хөгжүүлэлт учир дутагдалтай байна

Аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтэс health.gov.mn, нэгдсэн эмнэлэг e-health, сум өрхийн эрүүл мэндийн төвүүд health.gov.mn цахим системийг ашиглаж байгаад 2022 оны 7 сараас e-hospital, хувийн эмнэлэг болон сувилал wings, эмийн сангууд [orion pharm](http://orion-pharm), erp, info зэрэг цахим системийг үйл ажиллагаандаа ашигладаг бөгөөд тухайн системүүд нь даатгалын байгууллагатай холбогддог байна. Эрүүл мэндийн байгууллагуудын ашиглаж байгаа цахим системийн хөгжүүлэлт болон нууцлалыг тухайн системийг хариуцагч компаниуд нь хариуцан ажилладаг байна.

Ehealth программын хувьд эмнэлгийн тусламж үйлчилгээнд ашигладаг СТ-2-ын хавсралт 4, СТ-1 хавсралт 5А маягт, аппарат шалгах болон мэдээгүйжүүлэлтийн зарлагын хяналтын хуудас, мэс заслын хяналтын хуудас, өндөр өртөгтэй шинжилгээний маягт зэргийг хөтлөх хөгжүүлэлт хийгдээгүйгээс эдгээр маягтыг гараар хөтлөн цахим өвчний түүхтэй нэгтгэдэг зэрэг нь эмч сувилагч нарын ажлын ачааллыг нэмэгдүүлж байна гэсэн санал тайлбарыг ирүүлсэн. Мөн ЭМДЕГ, хур системийн серверт доголдол үүсдэгтэй холбоотой амбулаторийн эмчийн үзлэг, яаралттай тусламж, түргэн тусламж дээр битүүмж үүсдэг, өвчний түүхээ илгээж чаддаггүй зэрэг цахим систем болон түүний хөгжүүлэлттэй холбоотой дутагдлууд байна.


Б2.3. Эрүүл мэндийн даатгалын байгууллагаас холбогдох хууль тогтоомжийн талаар сургалт мэдээллийг хийдэг хэдий ч энэ талаарх иргэдийн мэдлэг, мэдээлэл дутмаг байна

2021 онд Эрүүл мэндийн байгууллагуудад ЭМДҮЗ-ийн шинэчлэгдсэн тогтоол, ЭМД-ийн тухай хуулийн өөрчлөлт, нэхэмжлэлд хяналт хийх журам, ковид-19 халдварын үеийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлд тавих хяналт зэрэг сэдвээр 8 удаагийн сургалт, Аймгийн төвийн 6 байгууллагад ЭМД-ийн тухай хуулийн өөрчлөлт, edaatgal аппликейшны талаар 6 удаагийн сургалт, эрүүл мэндийн даатгалтай холбоотой сэдвээр цаг үеийн мэдээлэл аймгийн АВ телевизэд 3 удаа, Архангайн амьдрал сонинд 4 удаа нийтлэл гаргаж ажилласан байна.

2022 онд Өрхийн Эрүүл мэндийн төв, эмнэлгүүдтэй хамтран 2 удаа нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж, иргэд даатгуулагчдад 8 удаа, эрүүл мэндийн байгууллагуудад 29 удаа, төрийн болон төрийн бус байгууллагуудад 13 удаагийн сургалт мэдээлэл хийсэн байна. Мөн орон нутгийн АВ телевизэд цаг үеийн мэдээллүүдийг 5 удаа өгч, Архангайн амьдрал сонинд 4 удаа мэдээлэл бичиж хэвлүүлсэн байна.


Иргэд, олон нийтээс Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээ, даатгалын байгууллагын мэдээллийн ил тод байдлын талаар авсан санал асуулгын дүн дараах байдалтай байна. *График№3*

Эрүүл мэндийн даатгалаар ямар, ямар үйлчилгээг хөнгөлөлттэй үнээр авах талаар мэддэг үү?
129 responses



1. Эрүүл мэндийн даатгалаас хөнгөлөлттэй үнээр авдаг үйлчилгээний талаар мэдэх эсэхэд санал авахад оролцсон нийт иргэдийн 49.6 хувь нь “мэдэхгүй” гэж хариулсан байна.

Эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хэрхэн үнэлэх вэ?
129 responses



2. ЭМД-ын байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хэрхэн үнэлэх вэ? Гэсэн санал асуулгад оролцсон нийт иргэдийн 51.9 хувь нь “дунд” 20.2 хувь нь “муу” гэж хариулсан байна.

Аудитаас иргэд олон нийтийн дунд Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, холбогдох эрх зүйн актын талаар ойлголт, мэдлэг мэдээлэл дутмаг байгаа нь иргэдээс авсан санал асуулгаас харагдаж байгаа тул энэ чиглэлийн мэдээллийн хүртээмжийг сайжруулахад үр дүнтэй арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтэст хүргүүлээ.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.2."эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар болон төлбөрийн талаар даатгуулагчийн гаргасан өргөдөл, гомдол, саналыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэж, даатгуулагчийн эрхийг хамгаалах" гэж заасан байна.

Аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтэст 2021 онд ковид-19-ын тусламж үйлчилгээтэй холбоотой 1 , 2022 онд эмийн үнийн хөнгөлөлттэй холбоотой 1, эмийн сангийн үйлчилгээтэй холбоотой 1 нийт 3 өргөдөл гомдол ирснийг хянаж шийдвэрлэсэн байна.

2021 онд 1 иргэнээс ковидын халдвар авч эмчилгээнд зарцуулсан нийт 606.5 мянган төгрөгийн эм тарианы зардлыг даатгалын сангаас гаргуулах өргөдөл ирснийг шалгаж тухайн хүн нь өрх, сумын эрүүл мэндийн төвдөө хандаагүй гэрээр эм тариа авч хэрэглэсэн байсан тул даатгалын сангаас зардлыг санхүүжүүлэх боломжгүй гэсэн хариуг өгсөн байна.

2022 онд 1 эмийн сан даатгуулагчид левоксин 500 мг N10 эмийг флексид 500 мг N11 гэж борлуулсан гомдол ирсэнд тухайн байгууллагад албан шаардлага хүргүүлж иргэнд эмийн үнийг буцаан олгож гомдолгүй болгосон бол 1 даатгуулагч эмчийн жороор эмээ хөнгөлөлттэй үнээр авах гэхэд хөнгөлөлтийг эдэлсэн байна гэсэн гомдол ирснийг ЭМДЕГ-т хүргүүлэн УБ хотод даатгуулагчийн регистрийг ашиглаж байсан зөрчлийг таслан зогсоож гомдлыг барагдуулж ажилласан байна.

Орон нутгийн эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь хяналтыг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж байна

Б3.2. Орон нутгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар болон төлбөрийн нэхэмжлэлд холбогдох стандарт, журмын дагуу хяналтыг хэрэгжүүлж байна

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.3-т “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын болон төлбөрийн хяналтыг энэ хуулийн 14.8.7-д заасан журмын дагуу цахим болон бусад хэлбэрээр хэрэгжүүлэх” гэж заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2021 оны 05 дугаар тогтоол, 2022 оны 12 дугаар тогтоолоор баталсан Эрүүл мэндийн байгууллагаас гэрээний дагуу худалдан авах тусламж үйлчилгээний чанар болон төлбөрийн хяналтыг хэрэгжүүлэх “Чанар төлбөрийн хяналтын журам”-ын хүрээнд хяналт тавин ажиллаж байна.

Журамд заасан хяналтын төрлүүдээс орон нутагт гэрээний гүйцэтгэлийг шалгуур үзүүлэлтээр үнэлэх, нэхэмжлэлийн, эрүүл мэндийн байгууллага дээр очиж хийх хяналт гэсэн 3 төрлийн хяналт хийгдэж байна.

Аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь гэрээт эрүүл мэндийн байгууллагуудаас ирүүлсэн бүх нэхэмжлэлд цахим болон эмч байцаагчийн хяналтыг хийж байна. Хүснэгтээр харуулбал байна.

Хүснэгт №4 Эрүүл мэндийн байгууллагуудаас ирүүлсэн нэхэмжлэлд хийсэн хасалтын судалгаа /Сая.төгрөг/

Байгууллагын нэр		Ирсэн нэхэмжлэл		Хасагдал					
				Нийт		Үүнээс:			
						Системийн хасагдал		Эмч, байцаагчийн хасагдал	
Төрөл	Тоо	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
2021 он									
Нэгдсэн эмнэлэг	1	143659	12,466.1	2864	1,176.9	2705	112.5	159	1,064.4
Хувийн эмнэлэг	6	3858	2,317.5	85	225.1	65	30.5	20	194.6
Сумын ЭМТ	19	130288	6,918.5	1726	1,369.5	873	32.4	853	1,337.1
Өрхийн ЭМТ	3	32877	666.2	47	60.4	9	0.5	38	59.9
Сувилал	1	1001	728.0	43	78.9	29	12.3	14	66.6
Эмийн сан	45	55970	1,495.7	86	6.0	86	6.0	-	-
НИЙТ ДҮН	75	367653	24,592.0	4851	2,916.8	3767	194.2	1084	2,722.6
2022 он									
Нэгдсэн эмнэлэг	1	132239	12,180.3	4035	1,072.3	2760	472.8	1275	599.5
Хувийн эмнэлэг	6	2908	1,563.8	76	133.1	42	71.7	34	61.4
Сумын ЭМТ	19	209481	13,211.3	1425	475.8	692	437.8	733	38.0
Өрхийн ЭМТ	3	20051	1,267.6	313	49.6	6	0.5	307	49.1
Сувилал	1	814	662.7	45	187.1	7	8.3	38	178.8
Эмийн сан	41	65616	1,702.4	161	7.9	161	7.9	0	-
НИЙТ ДҮН	71	431109	30,588.1	6055	1,925.8	3668	999.0	2387	926.8

Хүснэгтээс харахад 2021 онд нийт 4851 хүний 2,916.8 сая төгрөгийн хасалт хийгдсэний 6.6 хувь буюу 194.2 сая төгрөг нь системийн, 93.4 хувь буюу 2,722.6 сая төгрөг нь эмч байцаагчийн хасалт хийж 44 зөвлөмж, 5.7 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож барагдуулсан байна.

2022 онд нийт 6055 хүний 1,925.8 сая төгрөгийн хасалт хийгдсэний 51.8 хувь буюу 999.0 сая төгрөг нь системийн, 48.2 хувь буюу 926.8 сая төгрөг нь эмч байцаагчийн хасалт хийж 101 зөвлөмж, 35.2 сая төгрөгийн зөрчил арилгуулах 4 албан шаардлага, 30.9 сая төгрөгийн 10 төлбөрийн акт тогтоож барагдуулсан байна.

2021 онд нийт нэхэмжилсэн дүнгийн 11.8 хувь нь хяналтаар хасагдсан бол 2022 онд нийт нэхэмжилсэн дүн өмнөх оноос 19.6 хувиар өссөн хэдий ч хасагдал 5.5 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа нь төлбөрийн нэхэмжлэлд холбогдох стандарт, журмын дагуу хяналтыг хэрэгжүүлж байна гэж үзэхээр байна.

2021 онд 7, 2022 онд 25 нийт 32 эрүүл мэндийн байгууллагад газар дээрх хяналтыг шалгалтыг хийж 4 зөвлөмж, зөрчил арилгуулах 5 албан шаардлага, 1.2 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож хэрэгжилтийг хангуулсан байна.

Гэрээний гүйцэтгэлийг шалгуур үзүүлэлтээр үнэлэх хяналтаар 2021 онд 65, 2022 онд 38 эрүүл мэндийн байгууллагыг хамруулж 4 байгууллагад зөрчил арилгуулах 4 албан шаардлага хүргүүлж хэрэгжилтийг хангуулж ажилласан байна.

Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудаас нэхэмжлэлийн хяналттай холбоотой ирүүлсэн санал, тайлбар. Үүнд:

- ✓ Хяналтын шалгуур үзүүлэлтүүд хэт хийсвэр, үйлчлүүлэгчдэд үзүүлсэн бодит үйлчилгээний чанарыг үнэлэхгүй байна.
- ✓ Нэхэмжлэлийн хяналтын дагуу хэвтэн эмчлүүлсэн нэг хүний зардлыг хасахад, нэхэмжилсэн тухайн оношийн бүлгээс хяналтгүйгээр, адилтган хувьчлан хасаж буй нь эрүүл мэндийн даатгалын хяналт нь гүйцэтгэлээр санхүүжүүлэх тогтолцоотой нийцэхгүй байна.

Б3.4. Аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтэст шилэн дансны цахим сайтад мэдээлэл байршуулах эрх байхгүй, ЭМДЕГ шилэн дансны цахим системийг нэгдсэн байдлаар хөтөлдөг байна. Мөн орон нутгийн ЭМДХ-г төсөв санхүүтэй холбоотой зарцуулалт гардаггүй тул Төрийн хэмнэлтийг тухай хуулийн хэрэгжилт үзэгдэхээргүй байна.

АУДИТЫН ДҮН, ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох баримт дүн дүгнэлтэд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна.

- ✓ Хөгжлийн бодлогын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгийн хүрээнд орон нутгийн эрүүл мэндийн чиглэлээр тусгагдсан арга хэмжээ 75.5% ийн хэрэгжилттэй үнэлэгдсэн байна.
- ✓ Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгож байгаа боловч орлого бүрэн төвлөрөхгүй байна.
- ✓ Эрүүл мэндийн даатгалын үр дүнд суурилсан тогтолцоонд шилжсэнээр эрүүл мэндийн салбарт тодорхой ахиц дэвшил гарах нөхцөл бүрдэж эхэлж байна.
- ✓ Орон нутгийн эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь хяналтыг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж байна.

“Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө”-нд хийсэн аудитаар нийт 22.1 сая төгрөгийн зөрчил илэрсэнд зөрчил арилгуулах албан шаардлага 1, зөвлөмж 3, 22.1 сая төгрөгийн 8 төлбөрийн акт тогтоолоо.

УЛАМЖЛАХ САНАЛ:

1. “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журам”-д “Сонгон шалгаруулалтыг **гурван жилд нэг удаа** нэгдсэн журмаар зохион байгуулна” гэсэн заалтыг эргэн харах, нэмэлт шалгаруулалтад хязгаарлалт тогтоохгүй, шаардлага хангасан эрүүл мэндийн байгууллага бүр оролцох боломжийг бий болгох нөхцөлөөр хангах саналыг ЭМДҮЗ-д уламжилж байна.
2. Эрүүл мэндийн даатгал, эрүүл мэндийн байгууллагуудын ашиглаж байгаа цахим системийн хоорондын уялдаа холбоо, хөгжүүлэлтийг сайжруулан нэгдсэн нэг цахим системд шилжүүлэх саналыг ЭМДЕГ-т уламжилж байна.
3. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг НДЕГ төвлөрүүлж, зарцуулалтыг ЭМДЕГ хариуцаж байгаа нь орлого, зарлагын нэгдсэн уялдаа холбоо хангагдахгүй байдал ажиглагдаж байгаа тул тогтолцоог эргэн харах саналыг уламжилж байна.

АУДИТААС ӨГӨГДСӨН ЗӨВЛӨМЖ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүн, тайланд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн даргад:

- ✓ "Бүртгэл тайлангийн маягтыг шинэчлэн батлах тухай" Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/355 дугаар тушаалын хавсралт маягтаар гаргаж байгаа бүртгэл, тайлан мэдээг алдаагүй үнэн зөв тайлагнаж ажиллах.
- ✓ Иргэд олон нийтийн дунд Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, холбогдох эрх зүйн актын талаарх ойлголт, мэдлэг, мэдээллийн хүртээмжийг сайжруулахад үр дүнтэй арга хэмжээ авч ажиллах
- ✓ Эрүүл мэндийн байгууллагуудад хяналт, шалгалт, чанарын үнэлгээнд хамрагдах эрүүл мэндийн байгууллагын тоог нэмэгдүүлэх, чанар, төлбөрийн хяналтад дүн шинжилгээ хийж тайлагнах чиг үүргийн хэрэгжилтийг бүрэн ханган ажиллах.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:




**АРХАНГАЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
ХЭЛТЭС**

Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65190
Утас:/Факс: (976) 7033 2978,
Цахим шуудан: arkhangai@emd.gov.mn,
Цахим хуудас: www.emd.gov.mn

2023.05.18 № 12/34
танай _____-ны № _____-т

АРХАНГАЙ АЙМАГ ДАХ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

“Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан
санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө”-нд хийсэн
аудитын тайлангийн төсөлд оруулах санал
байхгүй болно.

ДАРГА  Д.АЛТАНТУЯА



ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ:



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2023 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/27

Цэцэрлэг

Гүйцэтгэлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрх, Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 18.9, 2018 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн А/207 дугаар “Эрх үүрэг шилжүүлэх” тушаалын тавдугаар хавсралтын 1.3, 2.4 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Үндэсний аудитын газраас нэгдсэн удирдамжийн дагуу “Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө”-нд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай

2.Аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг хавсралтаар баталсугай.

3.Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар, аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтэст хүргүүлсүгэй.

4.Аудитын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийцлийн аудитын багийн ахлах аудитор (П.Цэцэгдулам)-т даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх
аудиторын 2023 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн /18/ тоот
тушаалын хавсралт

"Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтын тогтолцоо, үр нөлөө" аудитаар
хүргүүлсэн шийдвэрийн жагсаалт

№	Хүргүүлсэн шийдвэрийн				Огноо дугаар	Хэрэгжилтийг хариуцах	
	Утга	Мөнгөн дүн /сая.төг/	Тоо	Шийдвэр		Байгууллага нэр, албан тушаал	Овог нэр
1	Зөвлөмж хүргүүлэх тухай	0.0	3	Зөвлөмж өгөх	2023.05.18	Аймгийн ЭМДХ-ийн дарга	Д.Алтантуяа
2	Зөрчил арилгуулах тухай	0.0	1	Албан шаардлага	2023.05.18 364/A0360217	Аймгийн Нэгдсэн эмнэлэгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Б.Амгалан
3	Төлбөр барагдуулах тухай	2.7	1	Төлбөрийн акт	2023.05.18 67/A0360217	Аймгийн Нэгдсэн эмнэлэгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Б.Амгалан
4	Төлбөр барагдуулах тухай	6.6	1	Төлбөрийн акт	2023.05.18 70/A0360217	Өндөр-Улаан сумын ЭМТ-ийн дарга	О.Мөнхтуяа
5	Төлбөр барагдуулах тухай	3.3	1	Төлбөрийн акт	2023.05.18 69/A0360217	Өлзийт сумын ЭМТ- ийн дарга	Д.Эрдэнэчимэг
6	Төлбөр барагдуулах тухай	3.3	1	Төлбөрийн акт	2023.05.18 68/A0360217	Булган сумын ЭМТ- ийн дарга	А.Сурмаажав
7	Төлбөр барагдуулах тухай	2.9	1	Төлбөрийн акт	2023.05.18 71/A0360217	Хотонт сумын ЭМТ- ийн дарга	Д.Эрдэнэбулган
8	Төлбөр барагдуулах тухай	1.7	1	Төлбөрийн акт	2023.05.18 72/A0360217	Цэнхэр сумын ЭМТ- ийн дарга	Ө.Мөнхшүр
9	Төлбөр барагдуулах тухай	0.8	1	Төлбөрийн акт	2023.05.18 73/A0360217	Эрдэнэмандал сумын ЭМТ-ийн дарга	Г.Дэлгэрдалай
10	Төлбөр барагдуулах тухай	0.8	1	Төлбөрийн акт	2023.05.18 74/A0360217	Хашаат сумын ЭМТ- ийн дарга	П.Отгондулам
Төлбөрийн акты дүн		22.1	8				
Албан шаардлагын дүн		0.0	1				
Зөвлөмжийн дүн		0.0	3				
НИЙТ ДҮН		22.1	12				